# ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 01 сарын 06 өдөр | Дугаар №.01 | Улаанбаатар хот

"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн
2026 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.6 дахь хэсэг, Компанийн дүрмийн 6.10.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн 2026 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг нэгдүгээр хавсралтаар, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтэд үндэслэн компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг баталж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж болгосугай.

3. Компанийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг үзүүлэлт бүрээр ханган биелүүлж ажиллахыг "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Х.Ганчулуун)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга нарт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

| ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ: | “ЭРЧИСТ МОНГОЛ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| Б.ЕРЭН-ӨЛЗИЙ | Г.АМАРТҮВШИН |

ЭРЧИСТ МОНГОЛ ХХК

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн
01. дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

## "БЗӨБЦТС" ТӨХК-ИЙН 2026 ОНЫ ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

| № | Техник, эдийн засгийн үзүүлэлт | | Хэмжих нэгж | 2024 он гүйцэтгэл | 2025 он Төлөвлөгөө | 2025 он Гүйцэтгэл (ХБГ-ээр) | 2026 он төлөвлөгөө |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | x | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | **Худалдан авах цахилгаан** | | **сая кВт*ц** | **686.7** | **772.28** | **781.8** | **871.76** |
| | Түгээлтийн нийт алдагдал | хувиар | хувь | 5.78% | 5.45% | 5.30% | 6.73% |
| | | биетээр | сая кВт*ц | 39.7 | 42.1 | 41.4 | 58.6 |
| | Борлуулах ЦЭХ | | сая кВт*ц | 647.0 | 730.2 | 740.4 | 813.1 |
| 2 | **Нийт орлого** | | **сая төг** | **194,010.7** | **247,455.2** | **250,723.5** | **255,753.0** |
| | Үүнээс | Борлуулалтын орлого | сая төг | 154,181.1 | 209,041.1 | 212,831.6 | 217,562.8 |
| | | Түгээх үйлчилгээний орлого | сая төг | 37,804.4 | 36,854.4 | 36,854.4 | 36,854.4 |
| | | Үйл ажиллагааны бус орлого | сая төг | 2,025.2 | 1,559.7 | 1,037.5 | 1,335.7 |
| 3 | **Нийт зардал** | | **сая төг** | **193,406.3** | **247,443.2** | **255,237.7** | **268,276.2** |
| | Үндсэн үйл ажиллагааны зардал | | сая төг | 191,680.9 | 245,895.5 | 252,999.2 | 266,943.8 |
| | Үүнээс | ҮХЭ-ийн зардал | сая төг | 9,922.8 | 10,544.6 | 11,054.8 | 13,640.8 |
| | | Хангах, түгээх үйл ажиллагааны зардал | сая төг | 29,360.9 | 38,765.5 | 38,369.1 | 39,835.2 |
| | Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг | | сая төг | 152,397.2 | 196,585.4 | 203,575.3 | 213,467.9 |
| | Үйл ажиллагааны бус зардал | | сая төг | 1,725.4 | 1,547.7 | 2,238.6 | 1,332.4 |
| 4 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | | сая төг | 604.4 | 12.0 | (4,514.3) | (12,523.3) |
| 5 | **Татварын дараахь ашиг (алдагдал)** | | **сая төг** | **297.6** | **10.8** | **(4,514.3)** | **(12,523.3)** |
| 6 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | | төг | 1.00 | 1.00 | 1.02 | 1.00 |
| 7 | **Нийт авлага** | | **сая төг** | **2,730.8** | **1,534.1** | **2,653.9** | **1,500.0** |
| | Үүнээс | Хэрэглэгчээс авах ЦЭХ-ний авлага | сая төг | 2,606.6 | 1,534.1 | 2,653.9 | 1,500.0 |
| | | Бусад авлага | сая төг | 124.2 | | - | |
| 8 | **Нийт өр төлбөр** | | **сая төг** | **49,996.3** | **48,694.9** | **53,823.4** | **58,844.9** |
| | Үүнээс | Урт хугацаат өр төлбөр | сая төг | 42,133.6 | 48,694.9 | 32,193.5 | 43,594.9 |
| | | Богино хугацаат өр төлбөр | сая төг | 7,862.6 | - | 21,629.9 | 15,250.0 |
| 9 | Нийт ажиллагсад | | тоо | 531 | 565 | 547 | 552 |
| 10 | **Нийт цалингийн сан** | | **сая төг** | **19,498.7** | **25,168.5** | **24,057.5** | **25,482** |
| 11 | **Цахилгаан тасалдлын дундаж хугацаа Исайди** | | **минут** | **808.7** | **800.0** | **719.3** | **700.0** |
| 12 | **Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ, төсөл** | | **сая төг** | **5,902.1** | **7,170.5** | **6,938.7** | **9,703.1** |
| | Үүнд: | Ухаалаг тоолуурын системийг үргэлжлүүлэх төсөл | сая төг | | | | 3,687.0 |

---o0o---